Засгийн газрын 2018 оны … дугаар тогтоолын хавсралт

# "ОРОН СУУЦ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Нэг дэх үе шат (2018-2019 он) | | Хоёр дахь үе шат (2020-2023 он) | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Үндсэн | Хамтрагч |
| Нэг.Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | | | | |
| 3.1.1.иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх; | 1 | Дотоодын нийт бүтээгдэхүүний тодорхой хувийг зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад зориулдаг байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2018-2023 | - | - | Эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | - | ДНБ-ий 3-аас доошгүй хувийг зарцуулдаг болсон байна. | - | СЯ | БХБЯ, ХЗЯ |
| | 2 | Орон сууц, түүний дэд бүтцийг барих, ипотекийн зээлийн хямд эх үүсвэрийг бий болгох, өрсөлдөөнийг дэмжих зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбарыг Монгол Улсад нээх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2018-2023 | - | - | Хэрэгцээ шаардлагын судалгаа хийгдсэн байна. | - | Эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | - | СЯ | ХЗЯ |
| | 3 | Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан бондыг олон улсын хөрөнгийн зах зээл дээр борлуулах урьдач нөхцлийг бүрдүүлнэ. | 2018-2019 | - | - | Урьдач нөхцлийг бүрдүүлсэн байна. | - | Хоёрдогч зах зээл дээр бондыг борлуулж эхэлнэ. | - | СЯ | СЗХ, ХЗЯ |
| | 4 | Орон сууцны зээлийн гэрээт хадгаламжийн тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдийн орон сууцны зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ. | 2018-20190 | - | - | Тогтолцоо бүрдсэн байна. | - | Хэрэгжилтийг хангасан байна. | - | СЗХ | Арилжааны банкууд |
| | 5 | Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2019-2023 | Улсын төсөв | - | Хуулийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батлуулсан байна. | - | Хэрэгжилтийг хангасан байна. | 4,000,000.0 | СЯ | ХНХЯ, БХБЯ |
| 3.1.2.түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох; | 1 | Орон сууцны тухай хуулийг шинэчлэн боловсруулах хүрээнд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, ашиглах, түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, түрээсийн төлбөртэй холбогдсон харилцааг зохицуулна. | 2018-2019 | - | - | Эрх зүйн орчин бүрдсэн байна. | - | Хэрэгжилтийг хангасан байна. | - | БХБЯ | ХЗЯ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Орон сууцны барилга, хотхон, хороолол барих хөрөнгө оруулагчдад газар, бусад дэд бүтцийн асуудлыг хөнгөлөлттэй нөхцөлөөр шийдвэрлэн өгч, баригдсан орон сууцны нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх журмыг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2018-2019 | Хувийн хэвшил | - | Журмыг боловсруулж, батлуулсан байна. | - | Хэрэгжилтийг хангасан байна. | - | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 3.1.3.орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох. | 1 | Орон сууцны зээлийн даатгалын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдийн орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, банкны системийн зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. | 2018-2023 | - | - | Даатгалын оновчтой тогтолцоог бүрдүүлсэн байна. | - | Хэрэгжилтийг хангасан байна. | - | СЗХ | Арилжааны банкууд |
| Хоёр. Гэр хорооллын газрыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай дэд бүтэц бүхий ногоон барилгын шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | | | | |
| 3.2.1.гэр хорооллын өмчилсөн эдэлбэр газрыг тухайн газрын эздийн шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | 1 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж, барилгажуулах төслийн хүрээнд 20000 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | 1,800,000.0 | 10000 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 900,000.0 | 10000 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | 900,000.0 | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 2 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд 50000 айлын амины орон сууцыг шинээр барьж ашиглалтад оруулна. | 2018-2023 | Улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 4,800,000.0 | 6000 айлын амины орон сууц баригдана. | 576,000.0 | 44000 айлын амины орон сууц баригдана. | 4,224,000.0 | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 3 | Инженерийн хангамжийн "Дэд бүтэц" төвийг 200 байршилд барьж байгуулна. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | 18,091,500.0 | 50 дэд бүтцийн төвийг барьж байгуулна. | 180,915.0 | 150 дэд бүтцийн төвийг барьж байгуулна. | 17,910,585.0 | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 4 | Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, "Ногоон нуур" орчимд 1008 айлын орон сууцыг барьж ашиглалтад оуулна. | 2019-2023 | БНХАУ-ын буцалтгүй тусламж /Монголын талын хөрөнгө/ | 985.0 | Зураг төслийг боловсруулсан байна. | 985.0 | 1008 айлын орон сууц ашиглалтад орсон байна. | - | БХБЯ | ХХ |
| 3.2.2.төв, суурин газрын гэр хорооллыг суурин амьдралын нөхцөл, стандартыг бүрэн хангасан монгол дүр төрх бүхий сайжруулсан гэр, амины сууцны хороолол болгон хөгжүүлэх; | 1 | Дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдсан иргэдэд орон сууцны нөхцөл сайжруулах чиглэлээр орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээл олгох журмыг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2018-2023 | - | - | Журмыг боловсруулж, батлуулсан байна. | - | Журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | БХБЯ | СЯ, ХЗЯ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөгжүүлэх; | 2 | Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2018-2019 | Улс, орон нутгийн төсөв | 24,000.00 | Гэр хорооллын цахилгаан хангамжийн найдвартай байдал хангагдсан байна. | 24,000.00 | - | - | ЭХЯ | Нийслэлийн Засаг дарга |
| | 3 | Гэр хороололд шинээр бий болох орон сууц, түүний инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалтын хэвийн, найдвартай ажиллагааг хангах бүтцийн нэгжийг байгуулж ажиллуулна. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | Бүтцийн нэгжийг байгуулж, ажиллуулсан байна. | - | Үйл ажиллагаа нь тотворжсон байна. | - | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Мэргэжлийн байгууллагууд |
| 3.2.3.инженерийн хангамжийн гол шугам сүлжээ, барилга байгууламжийг барих ажлыг төр хариуцаж, санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэн орон сууц болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлэх; | 1 | Дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтын найдвартай байдлыг хангах, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээг өргөтгөх, шинэчлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | 36,016.0 | Дулааны шугам, сүлжээ өргөтгөх, тоноглолын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, найдвартай, үр ашигтай ажиллагаа дээшилсэн байна. | 16,016.0 | Ашиглалтын үр ашигтай, ашигт ажиллагаа дээшилсэн байна. | 20,000.0 | ЭХЯ | ЭХЗХ, холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчид |
| | 2 | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, ашиглалтад оруулна. | 2018-2021 | Улсын төсөв, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл | 750,000.0 | Цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж, барилга угсралтын | 150,000.00 | Цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан байна. | 600,000.00 | БХБЯ | Нийслэлийн Засаг дарга |
| | 3 | Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Баян-Өлгий, Дорнод, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн төвүүдэд цэвэрлэх байгууламж шинээр барих, шинэчлэх төслийг хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Гадаадын зээл тусламж | - | Зураг төслийг боловсруулсан байна. | - | Цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан байна. | - | БХБЯ | Аймаг, Нийслэлийн Засаг дарга |
| | 4 | Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | 200,000.0 | Гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ. | 80,000.0 | Төлөвлөсөн ажлыг 100 хувь гүйцэтгэнэ. | 120,000.00 | БХБЯ | Аймаг, Нийслэлийн Засаг дарга |
| 3.2.4.өндөр технологийн бие даасан дэд бүтцийг дэмжиж хөгжүүлэх, инженерийн хангамжид сэргээгдэх эрчим хүч, инженерийн төвлөрсөн ба бие даасан эх үүсвэрийг хослуулан хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх; | 1 | Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй айл өрх, албан газар болон аялал жуулчлалын баазуудад байгаль орчинд халгүй жорлон (био болон хуурай жорлон), хаягдал (саарал) усыг цэвэршүүлэн, дахин ашиглах төслийг хэрэгжүүлнэ. | 2018-2020 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | 5,000.00 | 10000 өрхийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон байна. | 5,000.00 | - | - | БОАЖЯ | БХБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Усны менежментийг боловсронгуй болгох, унднаас бусад хэрэгцээнд гадаргын ба хуримтлуулсан ус болон цэвэршүүлсэн процессын усыг хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ. | 2018-2023 | Төр, хувийн хэвшил | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | БОАЖЯ | БХБЯ |
| | 3 | Байгаль орчинд ээлтэй, өндөр технологийн тоног төхөөрөмж, барилгын материал үйлдвэрлэх, импортлоход дэмжлэг үзүүлэх бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн бий болгоно. | 2018-2023 | Гадаадын зээл тусламж | - | Бүтээгдэхүүн, бараа, ажил, үйлчилгээг тодорхойлсон байна. | - | Зээлийн бүтээгдэхүүн бий болсон байна. | - | БОАЖЯ | СЯ, БХБЯ |
| | 4 | Барилгын үйлдвэрлэлийг улирлын хамаарлаас гаргах, шинэ технологи, хийц, бүтээцийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, импортыг орлох ногоон барилгын материал үйлдвэрлэгчдийг гааль, татварын бодлогоор дэмжинэ. | 2018-2023 | Улсын төсөв | - | Хэрэгцээ шаардлагын судалгаа хийгдсэн байна. | - | Эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | - | БХБЯ | СЯ |
| | | Дүн | | | 25,707,501.00 | | 1,932,916.00 | | 23,774,585.0 | | |
| Гурав. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих чиглэлээр | | | | | | | | | | | |
| 3.3.1.хот, суурин газрын хэт төвлөрлийг сааруулах, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дагуул, хаяа хот, тосгодыг жигд тэнцвэртэйгээр хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх; | 1 | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутагт Буянт-Ухаа 2 хорооллын 2 дугаар ээлжийн 4320 айлын орон сууцны 60 барилга, 2500 хүүхдийн сургууль, 840 хүүхдийн цэцэрлэг, үйлчилгээний 6 барилга бүхий соёл амралтын бүсийг барьж байгуулна. | 2018-2023 | Гадаадын зээл тусламж | 315,200.0 | Буянт-Ухаа 2 хорооллын 2 дугаар ээлжийн барилга, байгууламжийг бүрэн барьж эхэлнэ. | 150,000.0 | Барьж дуусган, ашиглалтад хүлээлгэн өгнө. | 165,200.0 | БХБЯ | "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ |
| | 2 | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутагт Эко-Яармаг 1 төслийг хэрэгжүүлж, 1800 айлын орон сууц, 280 хүүхдийн цэцэрлэг, Үндэсний түүх, соёлын музей, биеийн тамирын талбай бүхий соёл амралтын бүсийг барьж байгуулна. | 2018-2020 | Гадаадын зээл тусламж | 125,000.0 | Эко-Яармаг төслийг хэрэгжүүлж эхэлнэ. | 25,000.0 | Төслийг дуусган, ашиглалтад хүлээлгэн өгнө. | 100,000.0 | БХБЯ | "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ |
| | 3 | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутагт "Буянт-Ухаа 3" төслийг хэрэгжүүлж, 706 айлын орон сууц, 150 хүүхдийн цэцэрлэгийг барьж байгуулна. | 2018-2020 | Гадаадын зээл тусламж | 53,700.0 | Төслийг хэрэгжүүлж эхэлнэ. | 3,700.0 | Төслийг дуусган, ашиглалтад хүлээлгэн өгнө. | 50,000.0 | БХБЯ | "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 5 байршилд шинэ суурьшлын бүсийг хөгжүүлж, 9400 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, тусламж | 705,000.0 | Хэсэгчилсэн төлөвлөлт хийгдэж, төсөл хэрэгжүүлэх урьдач нөхцлийг бүрдүүлсэн байна. | 2,500.0 | Шинэ суурьшлын бүсүүдийг хөгжүүлж, 9400 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна. | 702,500.0 | НЗД | "Нийслэлийн орон сууцны корпораци" ОНӨААТҮГ |
| 3.3.2.орон сууцны барилгын эрчим хүч (цахилгаан болон дулааны)-ий хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэлтийн тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээгээрээ төлдөг тогтолцоонд шилжих; | 1 | Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээнээс ялгарч буй хүлэмжийн хийг тооцох үндэсний онцлогт тохирсон аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, хүлэмжийн хийн тооллогын системийг хөгжүүлж, уг системийг ашиглах зааврыг боловсруулна. | 2018-2023 | НҮБХХ-ийн санхүүжилт | 658.8 | Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшинг тодорхойлсон байна. | 400.0 | Барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг тооцдог болсон байна. | 258.8 | БХБЯ | НҮХББ, ЭХЗХ |
| | 2 | Үндэсний онцлогт тохирсон эрчим хүчний хэмнэлттэй загвар төслүүдийг хэрэгжүүлнэ. | 2018-2020 | НҮБХХ-ийн санхүүжилт | 1,200.0 | Төслүүд хэрэгжсэн байна. | 1,000.0 | Загвар төслүүдэд эрчим хүчний аудит хийлгэсэн байна. | 200.0 | БХБЯ | НҮБХХ |
| | 3 | Ногоон барилгын төлөвлөлтийг боловсронгуй болгох зөвлөмж боловсруулна. | 2018-2019 | НҮБХХ-ийн санхүүжилт | 2.8 | Зөвлөмж боловсруулсан байна. | 2.8 | - | - | БХБЯ | НҮБХХ |
| | 4 | Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын орон сууцны барилгуудын дулааны хэрэглээг тоолууржуулах арга хэмжээг орон нутгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын орон сууцны барилгын 10 хувийг тоолууржуулсан байна. | - | Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын орон сууцны барилгын 50 хувийг тоолууржуулсан байна. | - | ЭХЯ | БХБЯ, ЭХЗХ, НЗДТГ, Дархан-Уул, Орхон аймгуудын ЗДТГ |
| | 5 | Орон сууцны барилгын эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. | 2018-2019 | - | - | Журам батлагдсан байна. | - | Журмыг хэрэгжүүлнэ. | - | ЭХЯ, ЭХЗХ | БХБЯ, БОАЖЯ |
| | 6 | Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны барилга барих, барилгын материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж мөрдүүлнэ. | 2018-2019 | - | - | Журам батлагдсан байна. | - | - | - | ЭХЯ, ЭХЗХ | БХБЯ, БОАЖЯ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3.орон сууцны барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, холбогдох норм, дүрэм, стандартыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр инженер, техникийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх; | 1 | Эрчим хүчний хэмнэлттэй барилгыг төлөвлөх, барих чиглэлээр салбарын инженер, техникийн ажилтнуудыг чадавхижуулах төсөл хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Гадаадын зээл тусламж | 1,000.0 | Төсөл хэрэгжүүлэх тооцоо, судалгааг хийж, төслийг эхлүүлсэн байна. | 200.0 | Төсөл амжилттай хэрэгжсэн байна. | 800.0 | БХБЯ | ЭХЗХ |
| | 2 | Барилгын дулаан хамгаалалтын норм БНбД 23-02-09-ийг Европын Холбооны Улсуудад мөрддөг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулна. | 2018-2019 | НҮБХХ-ийн санхүүжилт | 24.0 | БНбД шинэчлэгдсэн байна. | 24.0 | - | - | БХБЯ | НҮБХХ, БХТ |
| | 3 | Үндэсний онцлогт нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын шаардлагыг тодорхойлсон стандартыг боловсруулж, мөрдүүлнэ. | 2018-2023 | ННС | 30.0 | Стандарт батлагдсан байна. | 30.0 | Стандартыг мөрдүүлсэн байна. | - | БХБЯ | ЭХЗХ |
| 3.3.4.шинээр баригдах орон сууцны барилгын эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хүчин чадлын тодорхой хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шийдвэрлэх; | 1 | Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдал багатай, ногоон барилга, барилгын материал, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн цахим мэдээллийн нэгдсэн сан байгуулж, иргэдийг мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлнэ. | 2019-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 50.0 | Мэдээллийн нэгдсэн сан байгуулах урьдач нөхцөл бүрдсэн байна. | - | Мэдээллийн нэгдсэн санг байгуулсан байна. | 50.0 | БХБЯ | ХХ |
| | 2 | Орон сууцны барилгыг байнгын ашиглалтад хүлээн авах явцад эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг тодорхойлсон тооцоолол, үзүүлэлт, дүгнэлтийг комиссын баримт бичгийн бүрдэлд оруулах тогтолцоог бүрдүүлнэ. | 2018-2019 | - | - | Эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн байна. | - | - | - | БХБЯ | Холбогдох төрийн байгууллагууд |
| | 3 | Ногоон барилгын чиглэлээр үйл ажиллагаа чвуулж буй төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах зорилгоор "Ногоон барилгын зөвлөл"-ийн үйл ажиллагааг дэмжиж бэхжүүлнэ. | 2018-2019 | Улсын төсөв | 100.0 | "Ногоон барилгын зөвлөл"-ийн үйл ажиллагаа жигдэрсэн байна. | 100.0 | - | - | БХБЯ | Холбогдох төрийн байгууллагууд |
| 3.3.5.ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарах, инженерийн хангамжид эрчим хүчний хэмнэлттэй | 1 | Газрын хэт гүний дулааныг (1500м доош) ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулж, загвар төсөл хэрэгжүүлнэ. | 2018-2019 | Улсын төсөв | 3,000.0 | Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна. | 500.0 | Загвар төслийг хэрэгжүүлсэн байна. | 2,500.0 | БХБЯ | ХХ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг бүх талаар дэмжих; | 2 | Хаягдал усыг дахин ашиглах, саарал усны систем MNS BS 8525-1:2015 үндэсний стандартыг хэрэгжүүлнэ. | 2019-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 500.0 | MNS BS 8525-1:2015 үндэсний стандартыг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоог 10-д хүргэсэн байна. | 100.0 | MNS BS 8525-1:2015 үндэсний стандартыг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоог 50-д хүргэсэн байна. | 400.0 | БХБЯ | БОАЖЯ |
| | 3 | Инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх стандарт боловсруулж, мөрдүүлнэ. | 2018-2019 | ННС | 10.0 | Стандарт батлагдсан байна. | 10.0 | Стандартыг мөрдүүлсэн байна. | - | БХБЯ | СХЗГ |
| | 4 | Шуудуугүй технологийн аргаар инженерийн шугам сүлжээг сэргээн засварлах төсөл хэрэгжүүлж, нийслэлд ус, хангамж, ариутгах татуургын 24 км шугам сүлжээг доторлох ажлыг хийж гүйцэтгэнэ. | 2018-2020 | Гадаадын зээл тусламж | 15,200.0 | Төсөл хэрэгжүүлэх тооцоо, судалгааг хийж, төслийг эхлүүлсэн байна. | 6,080.0 | Төсөл амжилттай хэрэгжсэн байна. | 9,120.0 | НЗД | Харьяа байгууллагууд |
| | 5 | Шинээр төлөвлөх орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, загвар төслийг хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | Зураг төслийг боловсруулсан байна. | - | Төслийг хэрэгжүүлсэн байна. | - | БХБЯ | ХХ |
| 3.3.6.орон нутгийн засаг захиргаа, сууц өмчлөгчдийн оролцоотойгоор дулааны алдагдал ихтэй, угсармал орон сууцны барилгуудыг дулаалах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны барилгуудыг буулган, шинээр барих төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх; | 1 | Ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны барилгуудыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж, 3000 айлын орон сууцыг шинээр ашиглалтад оруулна. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 270,000.0 | 300 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна. | 27,000.0 | 2700 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна. | 243,000.0 | Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга | Харьяа байгууллагууд |
| | 2 | Нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилгуудад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийлгэж, паспортжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 6,000.0 | Нийтийн зориулалттай орон сууцны барилгуудын 10 хувийг паспортжуулсан байна. | 2,000.0 | Нийтийн зориулалттай орон сууцны барилгуудын 30 хувийг паспортжуулсан байна. | 4,000.0 | Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга | Харьяа байгууллагууд |
| | 3 | Угсармал орон сууцны барилгын дулаан-техникийн шинэчлэлтийн санхүүжилтийн механизмыг боловсруулах, дулаалгын төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Гадаадын зээл тусламж | 36,000.0 | Нийтийн зориулалттай угсармал 25 блок барилгад дулаан-техникийн шинэчлэл хийсэн байна. | 10.0 | Нийтийн зориулалттай угсармал 75 блок барилгад дулаан-техникийн шинэчлэл хийсэн байна. | 35,990.0 | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.7.эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны санхүүжилтийг дэмжих боломжит эх үүсвэрүүдийг судалж, нэвтрүүлэх; | 1 | Орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн зээл, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ. | 2018-2023 | НҮБХХ-ийн санхүүжилт | 676.8 | Барилгын эрчим хүчний хэмнэлтийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг гаргасан байна. | 450.0 | Бүтээгдэхүүнийг төр, хувийн хэвшлийн санхүүгийн 3 байгууллагын зээлийн багцад тусгасан байна. | 226.8 | БХБЯ | НҮБХХ |
| | 2 | Ногоон хувийн сууц" загвар төслийг 2 байршилд хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Уур амьсгалын ногоон сан | 10,450.0 | Зураг төслийг боловсруулсан байна. | 450.0 | Загвар төслийг хэрэгжүүлсэн байна. | 10,000.0 | БХБЯ | БОАЖЯ |
| 3.3.8.циркуляр эдийн засаг (circular economy)-ийн загварт шилжих, орон сууцны барилгын хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох; | 1 | Өдөрт 2000 тн хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | 2018-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 3,000.0 | Улаанбаатар хотын хог хаягдлын 50 хүртэлх хувийг дахин боловсруулдаг болсон байна. | 600.0 | Улаанбаатар хотын хог хаягдлын 80 хүртэлх хувийг дахин боловсруулдаг болсон байна. | 2,400.0 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Хувийн хэвшил |
| 3.3.9.орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд хүртээмжтэй ил, далд авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулсан ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчинг бүрдүүлэхэд онцгойлон анхаарах. | | Гэр хорооллын хэт төвлөрлийг сааруулж, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлж, цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ. | 2018-2023 | Нийслэлийн төсөв | 70,467.4 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулсан байна. | 39,628.0 | Цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлсэн байна. | 12,604.4 | НЗДТГ | |
| | | Дүн | | | 1,546,802.4 | | 220,156.8 | | 1,324,245.6 | | |
| 3.4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардах хүүхдийг халамжилдаг эсхүл 0-18 насны 4 ба түүнээс олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эцэг, эх, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийг эрс сайжруулах чиглэлээр | | | | | | | | | | | |
| 3.4.1.гадаад, дотоодын буцалтгүй тусламжийн тодорхой хувийг зорилтот бүлэг, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулахад зориулах; | 1 | Хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцтай болох иргэдэд тавигдах шалгуур үзүүлэлтийг орлогын шатлал бүрэээр тогтоож, тэдэнд үзүүлэх хөнгөлөлтийн бодлогыг тодорхойлно. | 2019-2023 | - | - | Бодлогоо тодорхойлсон байна. | - | Бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | ХНХЯ | БХБЯ, ХЗЯ |
| | 2 | Зорилтот бүлгийн иргэдэд зориулж орон сууц барих хөрөнгө оруулагчид гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын зээл авах тохиолдолд Засгийн газар, Хөгжлийн банкнаас баталгаа гаргуулах ажлыг зохион байгуулна. | 2018-2023 | - | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | БХБЯ, СЯ | МУХБ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны барилгын бүтээн байгуулалтад эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи бүхий үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүнийг түлхүү ашиглана. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | БХБЯ | ХХ |
| 3.4.2.“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20000 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх; | 1 | Төлбөрийн чадварт нийцсэн, байнгын түрээсийн орон сууцыг дэмжих замаар хувийн хэвшлийн 6500 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах ажлыг зохион байгуулна. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | 1000 өрхийг орон сууцжуулсан байна. | - | 5500 өрхийг орон сууцжуулсан байна. | - | БХБЯ | Хувийн хэвшил |
| | 2 | Зах зээл дээр борлуулагдаж байгаа орон сууцнуудаас худалдан авах замаар хямд өртөгтэй төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн 8500 айлын орон сууцны сан бүрдүүлнэ. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | 637,500.0 | Шинээр 2000 айлын түрээсийн орон сууцны сан бүрдсэн байна. | 150,000.0 | Шинээр 6500 айлын түрээсийн орон сууцны сан бүрдсэн байна. | 487,500.0 | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 3 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон орон сууцыг тодорхой хугацаанд түрээслэж, улмаар өөрийн өмчлөлийн орон сууцтай болох эрх зүйн орчныг бүрдүүлж, зорилтот бүлгийн 5000 өрхийг орон сууцжуулах ажлыг зохион байгуулна. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | 1000 өрхийг орон сууцжуулсан байна. | - | 4000 өрхийг орон сууцжуулсан байна. | - | БХБЯ | Хувийн хэвшил |
| 3.4.3.ядуурлын түвшингээс доогуур орлоготой 0-18 насны 4-ээс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг /эх/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг тэргүүн ээлжинд түрээсийн орон сууцаар хангах бодлого барих; | 1 | "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлэх орон сууцны сангийн 70-аас доошгүй хувийг ядуурлын түвшингээс доогуур орлоготой 0-18 насны 4-ээс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг /эх/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд зориулна. | 2018-2023 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | БХБЯ | СЯ |
| | 2 | Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны түрээсийн төлбөрт татаас олгох асуудлыг шийдвэрлэнэ. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв | - | Зорилтот бүлгийг тодорхойлж, холбогдох журмыг боловсруулна. | - | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | ХНХЯ | СЯ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Өрхийн амьжиргааг дэмжих, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад хөтөлбөр, төслийг ядуурлын түвшингээс доогуур орлоготой иргэдийг орон сууцаар хангах, тэдний орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээтэй уялдуулан зохицуулна. | 2018-2023 | Улс, орон нутгийн төсөв | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | ХНХЯ | СЯ |
| 3.4.4.батлан хамгаалах, төрийн цэргийн байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсдыг орон сууцаар хангах арга хэмжээг тэдний цалин, орлогын түвшинтэй уялдуулан орон сууцны ипотекийн зээлийн уян хатан бодлогоор дэмжих; | 1 | Ажиллагсдадаа зориулж, орон сууцны жишиг хотхон, хорооллыг барьж, байгуулахыг бүх талаар дэмжиж, газар, дэд бүтцийн хангамжийн асуудлыг хөнгөлөлттэй нөхцлөөр шийдвэрлэнэ. | 2018-2023 | - | - | Жил бүрийн газар зохион байгуулалт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна. | - | Жил бүрийн газар зохион байгуулалт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна. | - | Аймаг, нийслэлийн Засаг дарга | БХБЯ |
| | 2 | Төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад нь олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг орон сууцны урьдчилгаанд шилжүүлэн тооцуулах боломжийг бүрдүүлнэ. | 2018-2019 | - | - | Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. | - | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | СЯ | ХЗЯ |
| | 3 | Орон сууцны ипотекийн урт хугацаатай зээлд хамрагдсан, бага, дунд орлоготой иргэдийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2018-2019 | - | - | Эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | - | Хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | СЯ | УТЕГ |
| 3.4.5.төв, суурин газраас алслагдсан газар, нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, залуучууд, мэргэжилтэй боловсон хүчний ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны зээлийг түлхүү олгох, орон сууцаар хангах; | 1 | Орон нутгийн төсвөөс жил бүр тодорхой санхүүжилтийг гаргаж, тухайн орон нутагт ажиллах төрийн албан хаагч, залуучууд, мэргэжилтэй боловсон хүчнийг орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ. | 2018-2019 | Орон нутгийн төсөв | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга | ХХ |
| 3.4.7. өрхийн амьжиргааг дэмжих, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад хөтөлбөр, төслийг ядуурлын түвшингээс доогуур орлоготой иргэдийг орон сууцаар хангах, тэдний орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээтэй уялдуулан зохицуулах | 2 | Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд баригдсан орон сууцнаас худалдан авах, дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдаж амины орон сууц барих иргэнд орон сууцны урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох ажлыг зохион байгуулна. | 2018-2019 | Улсын төсөв, гадаадын зээл тусламж | - | Эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | - | Зээлийг олгож эхэлсэн байна. | - | СЯ | БХБЯ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зохицуулах. | | | | | | | | | | | |
| | | Дүн | | | 637,500.0 | | 150,000.0 | | 487,500.0 | | |
| | | Нийт дүн | | | 27,891,803.4 | - | 2,303,072.8 | - | 25,586,330.6 | | |